



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/К/17

Хэрлэн сум

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн нутаг дэвсгэрт суурьшлын бүс руу хүрэн баавгай орж мал амьтан үргээж, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж болзошгүй нөхцөл байдал үүссэн тул иргэдийг зэрлэг амьтны халдлагаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах ажлыг удирдан зохион байгуулах, зөвлөмж, чиглэл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга	Б.Нандинбаатар	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Б.Батсүрэн	Цагдаагийн газрын дэд дарга Цагдаагийн хошууч
	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын дэд дарга
	Н. Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	Э.Хонгорзул	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга
	О.Цэндгомбо	Онон Балж-Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга
	С.Дамдинсүрэн	Амьтан хамгаалах нийгэмлэг төрийн бус байгууллагын тэргүүн (зөвшилцсөнөөр)

2. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

